



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 20/04

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/09 дүгээр захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/09 дүгээр захирамжийн хавсралтын дагуу төсөвт өртөг нь нэмэгдэж, зураг төсөл нь магадлалаар батлагдсан төсөл, арга хэмжээний ажилд нэмэлт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Н.Энхбаяр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.


4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Ундармаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.МОНХБАТ



Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны
өдрийн дүгээр тушаалын хавсралт



8

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Н.ЭНХБАЯР

(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Бүсийн Ахлах инженер)

ГИШҮҮД:

Г.ТЭМҮҮЖИН

(НЗДТГ-ын Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн Эрчим
хүчний бодлого төлөвлөлт
хариуцсан мэргэжилтэн)

Л.БОЛОРЧУЛУУН

(НХОГ-ын Хууль, дотоод хяналтын
хэлтсийн Хуулийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Ц.БЯМБАЖАВ

(Баянгол дүүргийн 5 дугаар
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Т.УНДАРМАА

(НХОГ-ын Төлөвлөлт судалгааны
хэлтсийн Төлөвлөлт судалгааны
мэргэжилтэн)